

Улсын бүртгэлийн дугаар

.....

Аравтын бүрэн

Ангиллын код:

Нууцын зэрэглэл: Б

Төсөл хэрэгжүүлэх

гэрээний дугаар

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭН

ГЕОСОРОНЗОН ОРНЫ МЭДЭЭЛЛЭЭР ГАЗРЫН ГАДАРГААР АЛДАГДАХ ДУЛААНЫ УРСГАЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Шинжлэх ухааны академийн грант төслийн тайлан

2022-2023

Төслийн удирдагч: Г.Баянжаргал– Доктор (Ph.D),

Одон орон геофизикийн хүрээлэнгийн

эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Шинжлэх ухааны академи

Тайлан өмчлөгч:

Шинжлэх ухаан, технологийн сан

РЕФЕРАТ

Булган аймгийн Могод сумын нутагт орших Хульжийн халуун рашааны орчмын (100х100км²) талбайд цэгцтэй байрлуулсан 750 орчим цэгт геосоронзон орны үнэмлэхүй утгыг хэмжив. Энэ хэмжсэн утгаас чулуулаг давхаргад үүсгүүртэй аномаль геосоронзон орны утгыг ялган, энэ талбайд харгалзах аномаль геосоронзон орны түгэлтийн хоёр хэмжээст зураглалыг гаргав. Мөн энэ аномаль орны утгуудад шинжилгээ хийж, чулуулаг давхаргын соронзон шинж чанар алдагдах Кюри гүнийг тогтоосон. Энэ Кюри гүний утгуудад температурын градиентыг тооцох аргаар уг талбайд харгалзах газрыг гадаргаар алдагдах дулааны урсгалын түгэлтийн хоёр хэмжээст зураглалыг гаргав. Дээрх талбайд харгалзах дундаж дулааны урсгал нь 60.3мВт/м² утгатай гарч байв. Энэ нь Улаанбаатар хотын Сонгино хайрхан уулыг багтаасан (40х40км²) талбайд харгалзах дундаж утга 46.7мВт/м²-аас их гарч байна. Яг Хульжийн халуун рашааны орчмын талбайд газрын гадаргаар алдагдах дулааны урсгал нь 70мВт/м² орчим гарч байв. Бид цаашид Хульжийн халуун рашааны орчмын талбайг цахилгаан-соронзон аргаар нарийвчлан судлах төлөвлөгөөтэй байна.

ТҮЛХҮҮР ҮГ

Аномаль геосоронзон орон
Дулааны урсгал
Кюри цэг

ГҮЙЦЭТГЭГЧИД

Гэндэнпунцагийн Баянжаргал, Одон орон геофизикийн хүрээлэн, доктор (Ph.D).

Шоовдорын Цэрэндүг, Одон орон геофизикийн хүрээлэн, докторант.

Түмэнгийн Насан-очир, Одон орон геофизикийн хүрээлэн, магистрант.

НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ЖАГСААЛТ

Аномаль геосоронзон орон- чулуулгийн үүсгэж байгаа байрлалаас хамаарсан гаж соронзон орон

Температурын градиент- Температурын чиглэлээс хамаарсан өөрчлөлт

Кюри цэг- Бодисын физик шинж чанар огцом өөрчлөгдөх цэг

Литосфер- Дэлхийн чулуулаг үе давхарга

Локаль геосоронзон- Байрлалаас хамаарсан шинж чанартай соронзон орон

MMPOS-1 магнетометр- Дэлхийн соронзон орны бүрэн хүчлэгийг хэмждэг багаж

IGRF-Олон улсын геосоронзон орны жишиг загвар

Парасоронзон- Бодисын хувийн соронзон шинж чанар алдагдсан төлөв

Ферросоронзон- Бодис хувийн соронзон шинж чанартай байх үеийн төлөв

ГАРЧИГ

I. Оршил	5
II. Геосоронзон орны ангилал	6
2.1 Гадаад эх үүсвэртэй	6
2.2 Үндсэн геосоронзон орон	7
2.3 Аномаль геосоронзон орон	8
III. Аномаль геосоронзон орныг ялгах	10
3.1 Үндсэн орныг ялгах	10
3.2 Гадаад эх үүсгүүртэй орныг хасах	10
3.3 Могод орчмын Литосферийн аномаль геосоронзон орны түгэлт	12
3.4 Литосферийн аномаль геосоронзон орны шинж чанарууд	13
IV. Кюри цэгийн гүнийг олох	14
4.1 Тасралттай функцийн Фурьегийн хувиргалт	14
4.2 Аномаль орны үүсгүүрийн гүн ба Кюри цэгийн гүнийг олох	15
4.3 Газрын гадаргаар алдагдах дулааны урсгалыг үнэлэх	16
V. Дүгнэлт	18
VI. Ашигласан материалууд	20
VII. Хавсралт	21

I. Оршил

Дэлхийн температур гүнрүүгээ доошлох тусам нэмэгддэг. Литосферийн температур 580°C градус орчим болоход төмөр, кобальт, никлийн агуулга өндөртэй ферросоронзон төлөвт байсан чулуулаг парасоронзон төлөвт шилждэг. Өөрөөр хэлбэл, ойролцоогоор 580°C температуртай энэ цэг нь литосферийн ферросоронзон чулуулгийн парасоронзон төлөвт шилждэг фазын хувирлын цэг юм. Энэ фазын шилжилт болох 580°C температурыг Пьер Кюриин нэрээр Кюри температур гэж нэрлэдэг.

Литосферийн үүсгэж байгаа аномаль соронзон орон гэдэг нь энэ Кюри цэгээс дээш орших төмөр, кобальт, никель мэтийн ферросоронзон бодисын өндөр агуулгатай давхаргын үүсгэж байгаа орон болно.

Дэлхийн гадаргуу дээр хэмжиж байгаа геосоронзон орон нь олон эх үүсвэртэй нийлмэл орон юм. Тэр нийлмэл орноос литосферийн аномаль соронзон орныг ялган, энэ үе давхаргын зузааныг буюу Кюри цэгийн гүнийг тодорхойлох нь практикийн чухал ач холбогдолтой. Кюри цэгийн байрлал нь үргэлж тогтмол байдаггүй. Геологийн идэвхитэй үзэгдлийн нөлөөгөөр өөрчлөгдөж болно. Энэ өөрчлөлтийг Кюри цэгийн вариаци гэж нэрлэдэг. Кюри цэгийн вариацийг газрын гүнд өрнөж байгаа идэвхитэй үзэгдлүүдтэй холбон үзэж, тухайн идэвхитэй үзэгдлийг судлах нэгэн аргачилалд тооцох хандлага сүүлийн үед бий болсон. Энэ төрлийн судалгаа 2000-аад оноос хойш Ази, Европ, Америк тивийн улсуудын нутагт янз бүрийн талбайд хийгдэж байжээ. (Hsien-Hsiang , Chieh-Hung , Pei-Ying , & Horng-Yuan, 2014), (Nazif, 2010), (Ya , Tianyao , Hermann , & Fangzhou, 2016)

Тухайлбал Стамполидис нар (Stampolidis & Tsokas, 2002) Албани улсын нийт нутаг дэвсгэрт явуулсан судалгаагаар дээрх Кюри цэгийн гүнийг 17–25.5 км гэж тодорхойлсон байна.

Мөн Грекийн хойд нутагт хийгдсэн судалгаагаар Кюри цэгийн гүнийг 11.2 – 17.3 км гэж тодорхойлжээ (Stampolidis & Tsokas, 2002). БНХАУ-ын өмнөд Манжийн нутагт $180 \times 180 \text{ км}^2$ тэгш дөрвөлжин талбайд хийгдсэн судалгаагаар Кюриин цэгийн гүнийг дундаар 18–32 км, гүний дулаан дамжуулах чадварыг $1.8\text{--}3.2 \left[\frac{\text{Вт}}{\text{М}^{\circ}\text{C}} \right]$ гэж авсан байна.

Харин нэгж талбайгаар алдагдах дулааны урсгалын хэмжээг $(25\text{--}50) \left[\frac{\text{мВт}}{\text{М}^2} \right]$ гэж тооцоолжээ (Ya , Tianyao , Hermann , & Fangzhou, 2016).

Бид энэ грант төслийн хүрээнд Булган аймгийн Могод сумын Хульжийн халуун рашаан орчимд 100x100 км² талбай сонгон авч, геосоронзон орны мэдээллийг ашиглан газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын хэмжээг үнэлэх зорилго тавилаа. Мөн энэ талбайн аномаль геосоронзон орны түгэлтийн зураглалыг гаргав. Аномаль геосоронзон орныг үүсгэгч нь литосферт байх ферросоронзон бодисын агууламж өндөртэй үе давхарга ба бид энэ давхарга хүртлэх зайг тодорхойлов. Энэ давхаргын доод зааг буюу Кюри гадаргуугийн түгэлтийн 2 хэмжээст зураглалыг гаргав. Уг тайлан нь оршил, геосоронзон орны ангилал, аномаль геосоронзон орныг ялгах, Кюри цэгийн гүнийг олох, дүгнэлт, ашигласан материалууд, хавсрал гэсэн үндсэн 7 бүлэг, 11 зурагтай, 25 хуудсаас бүрдсэн болно.

II. Геосоронзон орны ангилал

2.1 Гадаад эх үүсвэртэй орон

Дэлхийн гадаргын ойролцоо хэмжигдэж байгаа геосоронзон орон нь олон эх үүсвэртэй соронзон орнуудын вектор нийлбэр орон юм. Үүнийг доорх хэлбэрт бичиж болно.

$$\vec{B} = \vec{M} + \vec{m} + \vec{B}_r + \vec{B}_{rv} + \vec{B}_a \quad (1)$$

\vec{M} -дэлхийн дотоод цөмд үүсгүүртэй хүчтэй туйлт орон. \vec{m} -эриний хувьсалт. \vec{B}_r -гадаад эх үүсвэртэй орон. \vec{B}_{rv} -гадаад эх үүсвэртэй орны вариаци. \vec{B}_a -Литосферт үүсгүүртэй аномаль соронзон орон.

Гадаад эх үүсвэртэй орон нь соронзон шуурга, соронзон лугшилт, дэлхийн эргэлтээс болж үүсэх хоногийн вариаци, сарны нөлөөгөөр үүсэх вариаци зэргийг оруулан тооцдог.

Соронзон шуурга нь наран дээрх тэсрэлтээс янз бүрийн ионууд ба протонууд цацагддаг. Энэ ионууд ба протонууд дэлхийн ионосфер ба магнитосфертэй харилцан үйлчлэлцснээс болж үүсэх үзэгдлийг соронзон шуурга гэдэг. Энэ үзэгдэл нь ерөнхийдөө глобал үзэгдэл боловч, туйлын бүсэд илүү тод эрчимтэй илэрнэ. Вариацийн үе нь 5 минутаас хэдэн 100 минут үргэлжилдэг. Геосоронзон обсерваторын бичлэг дээр тод бүртгэгддэг.

Соронзон орны лугшилт нь магнитосферт болж байгаа үзэгдлийн нөлөөгөөр үүсдэг. Уг үзэгдэл нь квазиглобаль үзэгдэл юм. Туйлын мужид илүү эрчимтэй ажиглагддаг. Ажиглагдах хамгийн их эрчим нь 10-ааднТл-100нТл. Лугшилтын вариацийн үе нь 1с-ээс 600 секунд хүртэл үетэй ажиглагдаж болно. Өндөр хурдтай индукцийн бичигчийн магнетограф дээр тодоор бичигддэг.

Дэлхийн эргэлдэх хөдөлгөөнөөс хамаарч нарны нөлөөгөөр үүсэх вариацийг нарны хоногийн вариаци S гэдэг. Нарны хоногийн S -вариацийн тайван байх үеийг S_q вариаци гэнэ.

Нарны хөөрөх хөдөлгөөний нөлөөгөөр үүсэх вариацийг S_1 , мөн атмосферын дулааны хөөрөх хөдөлгөөн ионосферт нөлөөлөн ионосферийг хөдөлгөөн оруулах ба түүнийг S_2 гэж тэмдэглэнэ. S вариаци нь S_1 , S_2 –оос зэрэг хамаардаг вариаци юм.

2.2 Үндсэн геосоронзон орон

M -дэлхийн дотоод цөмд үүсгүүртэй хүчтэй туйлт орон, түүний m -эриний хувьсалтыг дэлхийн үндсэн геосоронзон орон гэж нэрлэдэг. Үндсэн геосоронзон орон нь дэлхийн гадарга дээр хэмжигдэж байгаа нийт соронзон орны 90% гаруйг нь эзэлдэг. Энэ орныг доорх байдлаар загварчилдаг.

Соронзон орны индукцийн векторын дивергенц тэг байна гэдэг нь соронзон орныг үүсгэдэг цэнэг байхгүй гэдгийг харуулдаг тэгшитгэл юм.

$$\vec{\nabla} \cdot \vec{B} = 0 \quad (2)$$

Мөн ямар нэг вектор хэмжигдхүүн нь скаляр функцээс градиент авч, үүсгэж байгаа байдлаар бичиж болдог. Тиймээс геосоронзон оронг түүнийг үүсгэгч скаляр орноос градиент авах байдлаар бичье. Үүнийг доор бичив.

$$\vec{B} = -\vec{\nabla}\Psi \quad (3)$$

(3)-тэгшитгэлийг (2)-тэгшитгэлд орлуулан бичвэл доорхи тэгшитгэл гарна.

$$\Delta \cdot \Psi = 0 \quad (4)$$

(4)-тэгшитгэлийг Лапласын тэгшитгэл гэнэ. Ψ -геосоронзон орныг үүсгэгч скаляр потенциал юм.

(4)-Лапласын тэгшитгэлийг бодож геосоронзон орныг үүсгэгч скаляр потенциалыг олдог. Дэлхийн үндсэн соронзон орныг судлахад тэгш хэмт чанарт нь тохируулан бөмбөрцөг координатын системийг сонгон авч дээрх лапласын тэгшитгэлийн боддог.

$$\psi(r, \theta, \varphi) = \sum_{n=0}^{\infty} \sum_{m=0}^n \frac{D_n^m}{r^{n+1}} [g_n^m \cos(m\varphi) + h_n^m \sin(m\varphi)] P_n^m(\cos(\theta)) \quad (5)$$

Дэлхийн гадарга дээрх дурын цэг нь уртраг, өргөрөг, өндөр илэрхийлэгддэг ба тухайн цэгт дэх геосоронзон орны утгыг доорхи томъёогоор бодож олдог.


$$(\vec{M} + \vec{m}) = -\vec{V} \cdot \psi(r, \theta, \varphi) \quad (6)$$

θ -өргөрөг, φ -уртраг, $r=6371.3\text{км}+h$, h -далайн түвшнээс дээш тоолсон тухайн цэгийн өндөр.

2.3 Аномаль геосоронзон орон

Бодисын соронзон шинж чанарын анхдагч тайлбар нь атомын түвшинд хийгддэг. Өөрөөр хэлбэл атомын электронуудын үүсгэх соронзон моментууд нэмэгдсээр атомын ерөнхий соронзон моментыг үүсгэдэг. Гэвч ихэнх бодисын хувьд эдгээр атомын соронзон моментууд санамсаргүй тархалттай байх тул бие биенээ устган тэг болдог. Ийм бодисыг парасоронзон бодис гэдэг.

Менделеевийн үелэх системд бичигдсэн бодисууд дотроос төмөр Fe, кобальт Co, никель Ni гэх цөөхөн бодисуудын хувьд дээрх нийлбэр соронзон момент тэг болдоггүй. Ийм соронзон шинж чанартай бодисуудыг ферросоронзон бодисуудыг гэж нэрлэдэг. Ферросоронзон бодисын хувьд нийлбэр соронзон момент нь тэгээс ялгаатай домен гэж нэрлэгдэх олон жижиг хэсгүүдээс тогтоддог бөгөөд тэр жижиг хэсгүүдийн соронзон моментыг нийлбэрээр тухай бодисын ерөнхий соронзон момент тогтоогдоно.



Зураг 1(парасоронзон ба ферросоронзон бодисын диполын моментыг чиглэл.)

Ферросоронзон бодисыг халаахад тодорхой температурт хүрээд соронзон төлвийн фазын хувирал явагдаж парасоронзон төлөвт шилждэг. Энэ үзэгдлийн фазын хувиралт болох температурыг Пьер Кюриийн нэрээр Кюри температур гэж нэрлэдэг. Дэлхийн литосферийн давхаргад байдаг ферросоронзон бодисын хольц жигд биш, дэлхийн гадаргын соронзон нэвтрүүлэх чадвар харилцан адилгүй байдаг зэргээс локал аномаль соронзон орон үүсдэг.

Хэмжээний хувьд 100нТл-аас 10000 нТл хооронд байж болно. Энэ оронд хугацааны вариаци байхгүй. Цэвэр байрлалаас хамаарсан өөрчлөлттэй байдаг.

Сүүлийн жилүүдэд энэ аномаль геосоронзон орны судалгаанд олон улсын судлаачид ихээхэн анхаарал хандуулдаг болоод байна. Тухайлбал дэлхийн гадаргаас доошлох тусам дэлхийн температур ихэсдэг. Гүний температур 580⁰С орчим болоход тус чулуулаг давхаргад агуулагдаж байсан ферросоронзон бодис парасоронзон төлөвт шилждэг гэж үздэг. (Bansal, Anand, Rajaram, Rao, & Dimir, 2013), (Nazif, 2010), (Stampolidis & Tsokas, 2002).

Тиймээс дэлхийн гадарга дээрх чулуулгийн үүсгэх аномаль геосоронзон орон гэдэг нь энэ 580⁰С градустай цэгээс дээш байрлах ферросоронзоны хольцтой чулуулагийн үүсгэх орон аж. Хоёр хэмжээст тасралттай Фурье (2-D, DFT) анализын тусламжтайгаар энэ 580⁰С температуртай цэгийн байрлалыг тодорхойлох судалгаа 2000-аад оноос дэлхийн олон оронд хийгджээ. (Nazif, 2010), (Stampolidis & Tsokas, 2002), (Ya , Tianyao , Hermann , & Fangzhou, 2016), (Bansal, Anand, Rajaram, Rao, & Dimir, 2013). Бид энэ аргачиллын тухай 3-р бүлэгт бүлгүүдэд тодорхой бичсэн.

III. Аномаль геосоронзон орныг ялгах

3.1 Үндсэн орныг ялгах

Бид Булган аймгийн Могод сумын Хульжийн халуун рашааны орчим 100х100км.кв талбайд 3.6 км зайтай цэгүүд дээр геосоронзон орны утгуудыг хэмжсэн болно.

Хэмжилт хийсэн цэгүүдийн байрлалыг доорх зурагт үзүүлэв. Дэлхийн гадарга дээр хэмжигдэж байгаа орон нь олон үүсгүүртэй орны нийлбэр байдаг гэж дээр дурьдсан.

Бид энэ нийлмэл орноос аномаль геосоронзон орны утгыг ялган авах ёстой.

$(\vec{M} + \vec{m})$ -дэлхийн дотоод цөмд үүсгүүртэй хүчтэй туйлт орныг дээр бичсэн томъёогоор цэг нэг бүр дээр тооцоолон олоод тухайн цэг дээр хэмжигдсэн утгаас хасна.

$$(\vec{M} + \vec{m}) = -\vec{\nabla} \cdot \psi(r, \theta, \varphi) \quad (7)$$

$r=(6371.3+h)$ h -тухайн цэгийн далайн түвшнээс дээш хэмжсэн өндөр, 6371.3км далай түвшин хүртлэх дэлхийн радиус, θ -тухайн цэгийн өргөрөг, φ -тухайн цэгийн уртраг.


3.2 Гадаад эх үүсгүүртэй орныг хасах

Дээрх зурагт үзүүлсэн талбайн төв хэсэгт үл хөдлөх цэг сонгон авч тэр цэг дээр хэмжилт хийж байх нийт хугацаандаа $m_{\text{pross-1}}$ гэх магнетометрийг тасралтгүй ажиллуулав. Бид дээрх зурагт үзүүлсэн цэгүүд дээр хэмжилт хийж байх тухайн эгшин дэх үл хөдлөх цэгийн бичлэгийн утгыг хасах байдлаар гадаад орны нөлөөг хассан болно. Үүнийг доор дэлгэн бичив. Үл хөдлөх цэг дээр бичигдэж байгаа нийлбэр орныг доорх хэлбэрт бичиж болно.

$$\vec{B}_0 = \vec{M}_0 + \vec{m}_0 + \vec{B}_r + \vec{B}_{rv} + \vec{B}_{a0} \quad (8)$$

Үл хөдлөх цэгийн уртраг, өргөрөг, өндөршилт мэдэгдэж байгаа тул IGRF загвараар хэмжилт хийгдсэн өдрүүдийн хувьд үндсэн орон $\vec{M}_0 + \vec{m}_0$ -ийг (7)-томъёогоор тодорхойлж болно. Уг үл хөдлөх цэгийн \vec{B}_{a0} аномаль орныг w_{dmat} загварыг ашиглан тооцоолж олж болно.

Тэгвэл (8)-тэгшитгэлээс гадаад эх үүсвэртэй орныг ялган доорх хэлбэрт бичиж болно.



Зураг 2 (Могод орчмын (100x100км²) талбайд хэмжилт гүйцэтгэсэн цэгүүдийн байрлал)

$$(\vec{B}_r + \vec{B}_{rv}) = \vec{B}_0 - (\vec{M}_0 + \vec{m}_0) - \vec{B}_{a0} \quad (9)$$

\vec{B}_0 – нь үл хөдлөх суурин цэг дээр mmros-1–д бичигдэж байгаа геосоронзон орны утга, \vec{B}_{a0} –нь үл хөдлөх цэгийн орчимд wdmam загварыг ашиглаж олсон аномаль геосоронзон орон, $\vec{M}_0 + \vec{m}_0$ –нь үл хөдлөх цэг дээр дэлхийн үндсэн геосоронзон орны IGRF загвараар бодож олсон утга юм.

Хульжийн халуун рашаан орчимд 1-р зурагт үзүүлсэн тухайн цэгүүд дээр хэмжигдэж байгаа орныг доорх хэлбэрт бичиж болно.

$$\vec{B}_1 = \vec{M}_1 + \vec{m}_1 + \vec{B}_r + \vec{B}_{rv} + \vec{B}_{a1} \quad (10)$$

Бид (10)-тэгшитгэлээс (9)-тэгшитгэлийг хасаж дээрх цэгүүд дээр хэмжигдсэн геосоронзон орны утгаас гадаад эх үүсвэртэй орны нөлөөг устгана. Үүнийг доор бичив.

$$(\vec{M}_1 + \vec{m}_1 + \vec{B}_{a1}) = \vec{B}_1 - (\vec{B}_0 - (\vec{M}_0 + \vec{m}_0) - \vec{B}_{a0}) \quad (11)$$

$(\vec{M}_1 + \vec{m}_1 + \vec{B}_{a1})$ -эдгээр гишүүд нь тухайн цэгүүд дээрх эриний хувьсалт агуулсан локаль геосоронзон орны утга болно. (11)-тэгшитгэлээс IGRF загвараар олсон утгуудыг хасвал цэвэр литосферт үүсгүүртэй аномаль орон үлдэнэ. Үүнийг доор бичив.

$$\vec{B}_{a1} = \vec{B}_1 - \vec{B}_0 - \vec{\nabla} \cdot \psi_0(r, \theta, \varphi) + \vec{B}_{a0} + \vec{\nabla} \cdot \psi_1(r, \theta, \varphi) \quad (12)$$


Доорх зурагт үл хөдлөх цэгт байрлуулсан mpro-1 магнетометрийн зургийг үзүүлэв.



Зураг 3 (Суурин цэгт хээрийн хэмжилт хийж байгаа нь)

3.3 Могод орчмын Литосферийн аномаль геосоронзон орны түгэлт

Бид дэлхийн гадарга дээр хэмжигдэж байгаа нийлмэл орноос литосферт үүсгүүртэй аномаль геосоронзон орныг (12)-тэгшитгэлээр, 1-р зурагт үзүүлсэн бүх цэг дээр ялган авав. Энэ ялган авсан литосферийн аномаль геосоронзон орны утгуудын түгэлтийг доорх зурагт үзүүлэв.



Зураг 4 (Литосферийн аномаль геосоронзон орны түгэлтийн 2D зураглал)

3.4 Литосферийн аномаль геосоронзон орны шинж чанарууд

Литосферт ферросоронзон бодисын (Fe, Ni, Co) агуулга өндөртэй үе давхарга байдаг. Энэ үе давхаргын үүсгэж байгаа орныг литосферийн аномаль соронзон орон гэнэ.

Мөн дэлхийн температур доошлох тусам ихэсдэг ба 580°C болох үед (Fe, Ni, Co)-ферросоронзон бодисууд парасоронзон төлөвт шилждэг. Энэ гүнийг фазын хувиралтын Кюри цэг гэнэ. (Nazif, 2010), (Stampolidis & Tsokas, 2002)

Литосферийн аномаль геосоронзон орныг Кюри гүнээс дээш орших (Fe, Ni, Co)-ийн агуулга өндөртэй үе давхарга үүсгэдэг гэж хэлж болно.

IV. Кюри цэгийн гүнийг олох

4.1 Тасралттай функцийн Фурьегийн хувиргалт

Координатаас хамаарсан тасралттай функцийг Фурьегийн хувиргалтыг ашиглан давтамжаас хамаарсан долгионы (спектрийн) нийлбэр болгон бичиж болдог. (Blakely, 1995)

$$|B(k, l)| = \sum_{n=0}^{N-1} \sum_{m=0}^{M-1} f(n, m) e^{-i\omega(\frac{m}{M}k + \frac{n}{N}l)} \quad (13)$$

$$\rho(k_x, k_y) = |B(k, l)| = |B(k_x, k_y)| \quad (14)$$

Бидний тохиолдолд литосферийн үүсгэх аномаль геосоронзон орны энергийн нягтын спектрийг (14)-томъёогоор илэрхийлнэ.

Литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүр нь хэвтээ хавтгайн дагууд санамсаргүй зүй тогтлоор тархсан байдаг.

Харин энэ орны энергийн нягт нь радиусаас хамаарч экспоненциаль хуулиар суларсан байдаг.

$$|B(k_x, k_y)| = 4\pi^2 C_m^2 |\theta_m|^2 |\theta_f|^2 e^{-2|k|R_t} (1 - e^{-|k|(R_b - R_t)})^2 \quad (\text{Blakely, 1995}) \quad (15)$$

$|B(k_x, k_y)|$ - литосферийн аномаль геосоронзон орны утга, $k = \sqrt{k_x^2 + k_y^2}$

k_x, k_y -долгионы тооны хэвтээ байгуулагчид, C_m^2 - дундаж түгэлт, θ_m, θ_f -жижиг талбайн координатаас хамаарсан хэсгүүд. Эдгээдийг тооцон цэгцлэн бичвэл (15)-тэгшитгэл нь доорх хэлбэрт бичигдэнэ.

$$|B(k)| = D e^{-2|k|R_t} (1 - e^{-|k|(R_b - R_t)})^2 \quad (16)$$

$D = \text{const}, R_t, R_b$ -литосферийн аномаль геосоронзо орны үүсгүүрийн гүний дээд ба доод зааг.

(16)–тэгшитгэлийн хоёр талаас язгуур гарган, натурал логарифм авч бичвэл доорх хэлбэрт бичигдэнэ.

$$\ln(|B(k)|^{\frac{1}{2}}) \approx \ln(C) - kR_t \quad C = \text{const} \quad (17)$$

Аномаль геосоронзон орныг үүсгэгчийн төв хүртлэх зайг доор байдлаар бичиж болно.

$$R_0 = (R_b + R_t)/2 \quad (18)$$

R_0 -литосферийн аномаль орныг үүсгэж байгаа үе давхаргын төв хүртлэх зай.

(18)-тэгшитгэлийг (15)-тэгшитгэлд орлуулан цэгцлэн бичвэл бичвэл доорх тэгшитгэл гарна.

$$\overline{B}(|k|) = D \cdot e^{-2|k|R_0} (e^{-|k|(R_t-R_0)} - e^{-|k|(R_b-R_0)})^2 \quad (19)$$

(19)-тэгшитгэлийн хоёр талаас язгуур гаргаж, $d = |R_t - R_0| = |R_b - R_0|$ -болохыг тооцон бичвэл уг тэгшитгэл доорх хэлбэрт шилжинэ.

$$\overline{B}^{1/2}(|k|) = D^{1/2} \cdot e^{-|k|R_0} (e^{|k|d} - e^{-|k|d}) \approx D^{1/2} \cdot e^{-|k|R_0} \cdot 2|k|d \quad (20)$$

(20)-тэгшитгэлийн хоёр талыг k -д хуваан, натурал логарифм авч бичвэл доорх тэгшитгэл гарна.

$$\ln\left(\frac{\overline{B}^{1/2}(|k|)}{k}\right) \approx \ln(D) - kR_0 \quad (21)$$


$$R_b = 2R_0 - R_t \quad (22)$$

(22)-томъёогоор Кюри гүн буюу литосферийн 580°C температуртай цэгийн гүнийг олдог. (Nazif, 2010), (Stampolidis & Tsokas, 2002).

4.2 Аномаль орны үүсгүүрийн гүн ба Кюри цэгийн гүнийг олох

Бид жишээ болгож, 2-р зурагт үзүүлсэн шар цонхонд харгалзах цэгүүдийн литосферийн аномаль соронзон орны утгуудад Фурье анализ хийж, (17)-томъёогоор илэрхийлэгдэх хамаарлыг тогтоотоов. Энэ хамаарлын хэлбэрийг 5-р зурагт үзүүлсэн. Эндээс шугаман илэрхийллээр дүрслэгдэх хэсгээс литосферийн аномаль орны үүсгүүрийн дээд заагийг (17)-томъёогоор хялбар олж болно. Үүнийг 5-р зургийн доор жишээ болгон бичив. Мөн дээрх цонхонд харгалзах цэгүүдийн литосферийн аномаль геосоронзон оронд Фурье анализ хийж, (21)-томъёогоор илэрхийлэгдэх хамаарлыг тогтоов. Үүнийг 6-р зурагт үзүүлэв. Энэ хамаарлын шугаман хэсгээс (21)-томъёогоор литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн төв цэг хүртлэх зайг хялбар олж олно. Үүнийг 6-р зургийн доор жишээ

болгон бичив. Эндээс (22)-томъёогоор литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн ёроол буюу 580°C температуртай Кюри цэгийн гүнийг олж болно. Үүнийг жишээ болгож, 5 ба 6-р зургийн доор бичсэн болно.




зураг 5 (17-р тэгшитгэлд бичсэн хамаарал)

$$\ln(|B(k)|^{\frac{1}{2}}) \approx \ln(C) - kR_t$$

$$R_t = \frac{6}{0.35} = 17.6 \text{ km}$$

$$R_b = 2R_0 - R_t = 2 * 25.7 - 17.6 = 33.8 \text{ km}$$



зураг 6 (21-р тэгшитгэлд бичсэн хамаарал)

$$\ln\left(\frac{|B(k)|^{\frac{1}{2}}}{k}\right) \approx \ln(D) - kR_0$$

$$R_0 = \frac{9}{0.35} = 25.7 \text{ km}$$

Бид 2-р зурагт үзүүлсэн шар цонхийг судалгаанд хамаарагдсан бүх талбайн дагууд гүйлгэн дээрх зарчмаар литосферийн аномаль геосоронзон орныг үүсгүүрийн дээд цэг хүртлэх зай болон, 580°C температуртай Кюри цэгийн гүнийг олсон болно. Уг цэгүүдийг ашиглан гадаргуу зурж болох ба үүнийг доорх 7 ба 8-р зурагт үзүүлэв.

Мөн ингэж олсон 580°C температуртай Кюри цэгийн гүн, литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн дээд гадаргуу, хэмжилт хийгдсэн газрын гадаргуу зэргийг хамтад нь үе давхарга байдлаар дүрслэн үзүүлж болно. Эдгээр гадаргууг 9а-9с-р зурагт үзүүлэв. 9а ба 9с-р зурагт уг 3 хэмжээст гадаргууг янз бүрийн өнцгөөр эргүүлэх байдлаар үзүүлэв.

4.3 Газрын гадаргаар алдагдах дулааны урсгалыг үнэлэх

Кюри гүнээс дээш температурын градиентийн хамаарал нь доор тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ. (Nazif, 2010), (Stampolidis & Tsokas, 2002), (Ya, Tianyao, Hermann, & Fangzhou, 2016).

$$\frac{dT}{dR} = \frac{580^{\circ}\text{C}}{R_b} \quad (23)$$

$$q = \lambda \frac{dT}{dz} = \lambda \frac{580^{\circ}\text{C}}{R_b} \quad (24)$$

q -газрын гадаргаар алдагдах дулааны урсгал. λ -чулуулгийн дулаан дамжуулах чадвар. Галт уулын гаралтай хүрмэн чулуулаг $\lambda=(1.3-2.9) \left[\frac{W}{m^{\circ}C}\right]$, Боржин чулуулаг давамгайлж байвал дараах утгыг авна. $\lambda = (2.4 - 3.8)\left[\frac{W}{m^{\circ}C}\right]$.

Дээрх 2-р зурагт үзүүлсэн цонхны орчим нь Булган аймгийн нутаг дахь Авзага уулын ард хамаарах талбай бөгөөд энэ бүс нутгийн чулуулаг нь ерөнхийдөө боржин чулуу давамгайлсан байсан тул бид литосферийн дулаан дамжуулах чадварыг ойролцоогоор $\lambda = 3.3\left[\frac{W}{m^{\circ}C}\right]$ гэж авсан болно.

Бид энэ цонхны төв цэгт харгалзах газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын хэмжээг (24)-тэгшитглээр олж олно. Үүнийг жишээ болгож доор бичив.

$$R_b = 2R_0 - R_t = 2 * 25.7 - 17.6 = 33.8 \text{ km} \quad (25)$$

$\lambda = 3.3\left[\frac{W}{m^{\circ}C}\right]$ Авзага уулын орчмын чулуулгийн дулаан дамжуулах чадвар.

$$q = \lambda \frac{dT}{dz} = \lambda \frac{580^{\circ}\text{C}}{R_b} = 3.3 \frac{580^{\circ}\text{C}}{33.8} = 56.63 \left[\frac{mW}{M^2}\right] \quad (26)$$

2-р зурагт үзүүлсэн цонхыг гүйлгэн хэмжилт хийгдсэн бүх талбайн цэгүүд дээр газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын хэмжээг олж болно. Бид ингэж олсон газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын утгуудаар дулааны урсгалын түгэлтийн харуулж болно. Үүнийг 10-р зурагт үзүүлэв.

Могод орчмын ($100 \times 100 \text{ km}^2$) талбайн газрын гадаргаар алдагдах дундаж дулааны урсгалын хэмжээ нь $60.48 \left[\frac{mW}{M^2}\right]$ орчим гарч байна. Гэвч Хульжийн халуун рашааны орчимд уг дулааны урсгал хамгийн их $70 \left[\frac{mW}{M^2}\right]$ орчим гарч байв. Мөн хойшоо Ханжаргалант, Бугатын уулсын хөндийд орчимд гадаргын халуун усны илэрц байхгүй ч дулааны урсгалын хэмжээ нь харьцангуй их $(66-69) \left[\frac{mW}{M^2}\right]$ орчим гарч байна. Хульжийн голын сав дагууд урсгал нь дундажаар $62 \left[\frac{mW}{M^2}\right]$, Хульжийн нуруу, Могодын уулс, Хишиг-өндөрийн уулсаар газрын гадаргаар алдагдах дулааны урсгал

нь бага (49-53) $[\frac{mW}{M^2}]$. Судалгаанд хамаарагдсан энэ талбайн хувьд Сайхан уулын орчид дулааны урсгалын хэмжээ нь хамгийн бага 47-51 $[\frac{mW}{M^2}]$ гарч байна.

Мөн 2017 онд Улаанбаатар хотын баруун талд(40x40 km²) талбайд дээрх аргаар дулааны урсгалын түгэлтийн олсон болно. Улаанбаатарын орчмын талбайд хийгдсэн дулааны урсгалын түгэлтийг 11-р зурагт үзүүлэв. Энэ талбайн дундаж дулааны урсгалын хэмжээ нь 47.85 $[\frac{mW}{M^2}]$ гарч байв.

V. Дүгнэлт

1. Судалгаанд хамаарагдсан 100x100км.кв талбайн хувьд Хульжийн нуруу, Могодын нуруу, Сайхан уул, Хишиг-Өндөрийн уулсаар литосферийн аномаль геосоронзон орон нь (250-320) нТ, Авзага уулын арын хөндий, Хульжийн голын хөндий хойшоо Орхон голын хөндий зэрэг нам дор газарт (40-85) нТ орчим утгатай байна. Мөн энэ талбайн баруун хойно жижиг нуурын орчимд (-160÷-40) нТ гэсэн сөрөг утгатай байна.
2. Аномаль геосоронзон орон сөрөг утга авна гэдэг литосферт агуулагдах ферросоронзон чулуулгуудын доменуудын чиглэл нь дэлхийн үндсэн геосоронзон орны эсрэг чиглэлтэй байрласнаас болжээ.
3. Энэ талбайд литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн гүн нь Хульжийн халуун рашаан орчим, Хүрэмтийн уулсын хөндий, Сайхан уулын зүүн хөндийд (-12÷-10) км орчим гүн гэж гарч байна. Хишиг-өндөр, Дашинчилэнгийн уулс орчимд литосферийн аномаль орны үүсгэгчийн гүн нь (-14.5÷-12.1) км гүнтэй байна. Мөн литосферийн аномаль орны үүсгүүрийн хамгийн гүн утга нь Сайхан уулын орчим (-18.5 ÷-16.5) км гэж гарч байна. Хамгийн бага утга нь Хишиг-өндөр уулын урд хөндийд, Авзага уулын арын хөндий, Бугантын өвөр хөндийн болон Ханжаргалантын зүүн хөндийд (-8.5÷-6.5) км гүнтэй гэж гарч байна.
4. Литосферийн ферросоронзон шинж чанар алдагдах Кюри гүн нь Хульжийн рашаан орчим, Авзага уулын арын хөндий, Ханжаргалантын зүүн хөндийд (-27÷-30) км орчим байна. Энэ гүн нь Хишиг-өндөр, Могод, Бүрэгхангай зэрэг уулархаг бүст (-36÷-31) км орчим утгатай байна. Сайхан уулын орчимд Кюри гүн нь хамгийн гүнзгий (-37÷-41) км орчим утгатай байна.


5. Газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын хэмжээ нь Хульжийн халуун рашаан орчимд (65-70) $[\frac{mB\Gamma}{M^2}]$ ба нягтрал ихтэй гарч байна. Мөн Өгий, Ханжаргалантын зүүн хөндий орчмын гадаргын халуун усны илэрцгүй газарт тархвар байдлаар дулааны урсгалын хэмжээ нь (60-68) $[\frac{mB\Gamma}{M^2}]$ орчим гэж гарч байв.
6. Энэ судалгаанд хамаарагдсан нийт талбайн хувьд газрын гадаргаар алдагдах дундаж дулааны урсгалын хэмжээ нь 60.48 $[\frac{mW}{M^2}]$ гэж гарч байна.
7. 2017 онд Улаанбаатар хотын Сонгино хайрхан уулыг багтаасан (40x40км²) талбайд газрын гадаргаар алдагдах дулааны урсгалыг уг талбайн дундажаар 47.85 $[\frac{mW}{M^2}]$ тогтоосон болно. Үүнтэй харьцуулж үзвэл Могод орчмын (100x100км²) талбайн газрын гадаргаар алдагдах дундаж дулааны урсгалын хэмжээ нь 60.48 $[\frac{mW}{M^2}]$ буюу харьцангуй их байна.
8. Хульжийн халуун рашааны байрлал нь Хульжийн нурууны өвөрт өндөршлийн түвшин нь огцом буурч байгаа хөндий нам дор газар ба дулааны урсгалын хэмжээ нь судалгаанд хамрагдсан талбайн хувьд ч харьцангуй их гарч байна. Мөн Хульжийн халуун рашаан орчимд судалгааны дэд бүтэц хөгжсөн суурин газар тул цаашид геофизикийн бусад аргуудаар судлах бүрэн боломжтой. Манай салбарын судлаачид Хульжийн халуун рашаан орчимд магнетотеллурикийн нарийвчилсан судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

VI. Ашигласан материалууд


1. Bansal.A.R., Anand.S.P., Rajaram Mita, Rao VK, Dimri VP 2013. Depth to the bottom of magnetic sources (DBMS) from aeromagnetic data of central India using modified centroid method for fractal distribution of sources. *Tectonophysics* 603:155–161.
2. Blakely, R. (1995). Frontmatter. In *Potential Theory in Gravity and Magnetic Applications* (pp. I-Vi). Cambridge: Cambridge University Press.
3. Stampolidis. A., and Tsokas, G. N., 2002, Curie Point Depths of Macedonia and Thrace, N. Greece., *Pure and Applied Geophysics* Vol. 159, 2659-2671.
4. Nazif Maden 2010, Curie-point Depth from Spectral Analysis of Magnetic Data in Erciyes Stratovolcano (Central TURKEY), *Pure and Applied. Geophysics* Vol. 167, 349–358.
5. Ya Xu, Tianyao Hao, Hermann Zeyen and Fangzhou Nan., 2016, Curie Point Depths in North China Craton Based on Spectral Analysis of Magnetic Anomalies, *Pure and Applied. Geophysics* Vol. 173,1421-1430.
6. Hsien-Hsiang Hsieh, Chieh-Hung Chen, Pei-Ying Lin, Horng-Yuan Yen., 2014, Curie point depth from spectral analysis of magnetic data in Taiwan, *Journal of Asian Earth Sciences* 90, 26-33.

VII. Хавсралт


Хавсралт




Зураг 7 (Могод орчмын (100x100км²) талбайн литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн гүний түгэлтийн 2D зураглал)




Зураг 8 (Могод орчмын (100x100км²) талбайн литосферийн Ферросорзон шинж чанар алдагдах 580°C температуртай Кюри гадаргын түгэлтийн 2D зураглал)




Зураг 9a




Зураг 9b



Зураг 9с (Могод орчмын (100x100км²) талбайн литосферийн аномаль геосоронзон орны үүсгүүрийн гүн болон Кюри гүнийг газрын гадаргатай харьцуулан үзүүлсэн 3D зураглал)



Зураг 10 (Могод орчмын (100x100км²) талбайн газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын түгэлтийн 2D зураглал)



Зураг 11 (Улаанбаатар орчмын Сонгино хайрхан уулыг багтаасан (40x40км²) талбайн газрын гадаргаар алдагдах дулааны урсгалын түгэлтийн 2D зураглал)



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ГРАНТ МИНИ СИМПОЗИУМ

2021-2022 онд хэрэгжүүлсэн ШУА-ийн грант төслүүдийн үр дүнгийн хэлэлцүүлэг

Хэзээ: 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Хаана: ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Их чуулганы хурлын танхимд

- 09:00 Нээлт
- 09:05 GPS буюу байршил тогтоогч цогц хяналтын системийн нарийвчлалыг сайжруулж дотоодын зах зээлд нэвтрүүлэх нь
Д.Ууганбаатар, ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 09:25 Шинжлэх ухаан, боловсролын зүтгэлтэн академич А.Мекей
Б.Батгэрэл, ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 09:45 Академич Чулууны Далай: “Амьдрал үйлс, эрдмийн өв” сэдэвт бүтээлийн судалгаа
Р.Төрдалай, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, доктор (Ph.D)
- 10:05 XX зууны монголчуудын философийн өв
Б.Пүрэвсүрэн, ШУА-ийн Философийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 10:25 Говь-Алтай аймгийн археологийн дурсгалууд
Д.Базаргүр, ШУА-ийн Археологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 10:45 Дижитал (цахим тоон) эдийн засаг ба аж үйлдвэрийн IV хувьсгал
А.Даваасүрэн, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, доктор (Sc.D)
- 11:05 Нуурын орчин зүйг цөлжилтөөс хамгаалах, ногоон төгөлийг өргөжүүлэх
А.Дулмаа, ШУА-ийн Загас үржүүлгийн төв, академич
- 11:25 Хангайн дүүргийн цахиурлаг болон тунамал чулуулаг дахь радиолярийн судалгаа
Т.Оюунчимэг, ШУА-ийн Геологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 11:45 Зүүн Хэнтий, Эрээний нурууны Нарс, Дагуур болон Чскановын шинэс модны газрын дээрх биомассын судалгаа
Ч.Доржсүрэн, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, академич
- 12:05 Цайны завсарлага
- 12:20 Зарим зүйл шарилжийн удам зүйн холбоо хамаарлыг молекулын түвшинд тодорхойлох нь
Ө.Болортуяа, ШУА-ийн Биологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 12:40 10 гэв/с импульстэй протон-протон, протон-цөмийн харилцан үйлчлэлүүдийн фазын шилжилтийн судалгаа
Б.Отгонгэрэл, ШУА-ийн Физик, технологийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 13:00 Ботаникийн цэцэрлэгт тарималжуулж буй зарим өвслөг ургамлын эндомикоризын зүйлийн бүрдлийг тодорхойлох
Ц.Мөнхзул, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, доктор (Ph.D)
- 13:20 Зуун дамнасан үндэсний хэл бичгийн судлалын түүх
С.Байгалсайхан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор (Sc.D)
- 13:40 Оюуны өмч үнэлэх арга зүйн судалгаа
П.Баянсан, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт
- 14:00 Бэлчээрийн төлийн гүзээндэх шаахайнцрын зүйлийн бүрэлдэхүүнийг судалж, таних түлхүүр бичиг-ном зохиох
Ш. Дэмбэрэл, ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэн, академич
- 14:20 Архины бус шалтгаант элэг өөхлөх өвчин
Л.Тулгаа, Анагаах ухааны хүрээлэн, доктор (Ph.D)
- 14:40 Буудай (*Triticum Aestivum L.*)-н сортуудын навчны зэв өвчин (*Puccinia Triticina*)-ийг кодлогч маркер генийн судалгаа
Б.Одгэрэл, Хөдөө аж ахуйн их сургууль, доктор (Ph.D)
- 15:00 Геосоронзон орны мэдээллээр газрын гүний дулааны орны урсгалыг тодорхойлох
Г.Баянжаргал, ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн, доктор (Ph.D)
- 15:20 Цог сэтгүүлийн цахим мэдээллийн сан
Ж.Цэцэн, СУИС-ийн Соёлын сургуулийн багш, доктор (Ph.D)
- 15:40 Хэлэлцүүлэг
- 16:00 Хаалт

THE HEAT FLOW LOSING VIA EARTH'S SURFACE AROUND OF THE KHULJ'S HOT SPRING

Sh.Tserendug¹, G.Bayanjargal¹, T.Nasan-Ochir¹, Ts.Zolbadral²

Institute of Astronomy and Geophysics, Mongolian Academy of Sciences (MAS), Ulaanbaatar 13343, Mongolia¹

Nuclear Research Center, National University of Mongolia, Ulaanbaatar 13330, Mongolia²

E-mails: tserendug@iag.ac.mn, bayanjargal@iag.ac.mn, nasanochir@iag.ac.mn, zolbadral@mun.edu.mn

Abstract

In this paper, we extracted the values of geomagnetic anomaly sourced in lithosphere from the total intensity of geomagnetic that is measured on the 750 points on an area (100x100km²) around the Khulj's hot springs. The Curie Point Depth (CPD), which is lost magnetic properties of the lithosphere with 580 °C, was determined by the method of spectral analysis in the values of the geomagnetic anomaly as well. The heat flows lost on Earth's surface was also detected by the method of the gradient of temperature from the CPD. And the distribution (2D) map of heat flow around of the Khulj's hot spring were illustrated by the values of heat flows. Moreover, the average values of heat flow for whole the area (100x100km²) was about 60 [$\frac{mW}{M^2}$], and it was estimated at about 70 [$\frac{mW}{M^2}$] at the Khulj's hot springs.

Keywords: Curie point depth, Spectral analysis, Geomagnetic anomaly.

Introduction

